

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 09 сарын 18-ны
өдрийн 671.6 дугаарт бүртгэв.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 8 дугаар
сарын 29-ны өдөр

Дугаар А-165/385

Улаанбаатар хот


Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл,
зээлийн үйл ажиллагаанд баримтлах
шаардлагыг тогтоох тухай

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 400 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлагыг хавсралтаар баталсугай.

2.Банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан Монгол Улсын хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан журмыг хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээлийн үйл ажиллагаанд мөрдсүгэй.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай), Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд тус тус үүрэг болгосугай.





Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 8-р дугаар сарын 19-ний өдрийн А-165/325 дугаар хамтарсан тушаалын Хавсралт

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлага

1. Зээл нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх зорилготой байх;
2. Зээлийн дүн нь 100.0 тэрбум төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютын дүнгээс дээш байх;
3. Зээлийн хугацаа нь Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 7.3-т заасан шаардлагыг хангасан байх;
4. Зээл хүсэгч нь Монгол Улсад бүртгэлтэй, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээд байх;
5. Төсөл нь эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай, зээлийг эргэн төлөх чадвартай байх;
6. Төслийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн байх
7. Төслийн эрсдэлийн үнэлгээ, санхүүжилт авах үндэслэл, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр нөлөөг мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх.

